

2025

хагас жилийн тайлан

01

БИДНИЙ ТУХАЙ

Товч түүх
Эрхэм зорилго
Алсын хараа
Үнэт зүйлс
Дадал хэвшил

02

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХУРААНГУЙ

Онцлох үйл явдал
Санхүү байдлын тайлан, Орлого үр дүнгийн тайлан
Гүйцэтгэх дэд удирдлагын баг
Бүтээгдэхүүн хөгжүүлэлт
Эрсдэлийн удирдлага

03

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

АПУ Групп компанийн бүтэц
Хувьцаа эзэмшигчдийн хурал
Хувьцаа эзэмшигчдийн бүтэц
Төлөөлөн Удирдах зөвлөл
Ногдол ашгийн мэдээлэл
Компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийн өөрийн үнэлгээ
Хувьцааны арилжааны мэдээлэл

04

ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ

Ямагт орших өв соёл
Ногоон ба цэвэр тунгалаг
Хүчирхэгжсэн хамт олон
Баялаг, Хариуцлагатай
Тогтвортой түнш


OT

БИДНИЙ ТУХАЙ



1924

Зүүн сэлбийн баруун хөвөөнд таван Монгол, есөн Орос ажилтантай, архи найруулах, савлах гар ажиллагаатай үйлдвэрийг ашиглалтад оруулав.




1961

Ундаа хийжүүлэх, ханд бэлтгэх Болгар улсын тоног төхөөрөмжтэй ундааны цех байгуулав.



1988

“Оргилуун” брэнд шинээр мэндлэв. Ундааг 0.33 литрийн шилэн саванд савлах 12 мянган лонх\цагийн хүчин чадалтай урсгал шугам бүхий ундааны 2-р үйлдвэрийг шинээр байгуулав.




2001

“АПУ ХК”-ийн нийт хувьцааны төрийн мэдэлд байсан 51 хувийн хувьцааг нийтийн дуудлага худалдаагаар арилжсанаар “АПУ ХК” хувийн өмчид бүрэн шилжив.




2014

Сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулах тоног төхөөрөмжийн үйлдвэрлэлээр дэлхийд тэргүүлэгч Германы GEA компанитай хамтран шинэ сүүний үйлдвэрийг ашиглалтад оруулав.



2021

АПУ компани Монголын анхны нэг их наяд төгрөгийн үнэлгээтэй олон нийтийн компани болж, хүн төвтэй засаглалын бодлогыг шат дараатай амжилттай хэрэгжүүлж “Ажиллахад таатай газар” олон улсын сертификатыг Монгол улсдаа анх удаа гардан авав.




2024

АПУ компанийн улс эх орондоо оруулсан хувь нэмрийг үнэлэн, Монгол Улсын Ерөнхийлөгч зарлиг гарган “Хөдөлмөрийн гавьяаны улаан туг одон”-оор шагнав.



2024

Урт хугацааны зорилготой уялдсан тогтвортой хөгжлийн нөлөөллөө цар хүрээ, төвлөрөх чиглэлийн хувьд оновчилж, 'Бахархалт Монгол' Тогтвортой хөгжлийн стратеги 2030-аа баталлаа.



1924

1927

Шар айргийг Чех улсын мэргэжилтнүүдийн тусламжтайгаар Монголчууд анх удаа дотооддоо үйлдвэрлэж эхлэв.



1974

Монголд үйлдвэрлэсэн шар айргаа гадаадад экспортлож эхлэв.




1992

Архи Пивоны комбинатыг АПУ хувьцаат компани болгон зохион байгуулж, нийт хувьцааны 51 хувь төрийн мэдэлд, 49 хувь нь Монголын хөрөнгийн биржээр арилжаалагджээ.




2009

ХБНГУ-ын “Шмитт” компанийн орчин үеийн дэвшилтэт технологиор бүрэн тоноглогдсон “Альфа” буюу тансаг зэрэглэлийн спирт үйлдвэрлэх “Натур Агро” \тухайн үеийн нэрээр\ үйлдвэрийг ашиглалтад орууллаа.




2017

Нидерландын HEINEKEN компанийн Монгол дахь эзэмшлийн компаниудыг (М-БИ-СИ Азия Пасифик ХХК, Спирт Бал Бурам ХХК, СББ Трейд ХХК) өөртөө нэгтгэн хүчирхэг нэгдлийг бий болгов.



2023

Уламжлалт технологийг орчин үеийн тоног төхөөрөмжтэй хослуулан бүтээх, “Монгол бяслаг, Шигүдэри” урлах үйлдвэрийг ашиглалтад оруулж, Хонин нуга брэндийг худалдаанд гаргалаа.



2024

Нидерландын дэлхийд алдартай Хайнекен шар айргийг олон улсын стандартын дагуу АПУ компани цоо шинэжнээр нь дотоодод үйлдвэрлэж эхлэв.



2025

ҮРГЭЛЖ ӨӨДӨӨ

ЭРХЭМ ЗОРИЛГО

ШИНЭ САНАЛ САНААЧИЛГА, БҮТЭЭХ
ТЭМҮҮЛЛЭЭР УРЛАЖ БУЙ БҮХЭНДЭЭ
ҮРГЭЛЖ СЭТГЭЛЭЭ ШИНГЭЭНЭ.

АЛСЫН ХАРАА

ДЭЛХИЙД ТАНИГДАХ ЭРХЭМ МОНГОЛ
ХҮМҮҮНИЙ ОЮУН ЧАДВАР, УР УХААН,
ШИНЭЧЛЭЛ, **ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН**
УНДАРГА БАЙЯ.

ҮНЭТ ЗҮЙЛС

ТАНИХ
ЭРМЭЛЗЭЛ

ЭРЭЛ, ХАЙГУУЛЧ СЭТГЭЭ

Тасралтгүй шинийг эрэлхийлж,
суралцаж, хуваалцаж, туршья.

ҮНЭН
ЧАНАР

ХАМТДАА ЯЛЬЯ

Чанарыг эрхэмлэж, ялалтын
сэтгэлгээгээр урагшлая

БҮТЭЭЛЧ
ЧАДВАР

ИННОВАЦИЛАГ АЖИЛЛАЯ

Уламжлалаа хүндлэж, шинийг бүтээ

ХҮНЛЭГ
СЭТГЭЛ

ХҮНДЛЭН ЭРХЭМЛЭЭ

“Хүн” байхыг чухалчилж, сайн
сайхныг түгээ.



ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХУРААНГУЙ

Онцлох үйл явдал
Санхүү байдлын тайлан, Орлого үр дүнгийн тайлан
Гүйцэтгэх дэд удирдлагын баг
Бүтээгдэхүүн хөгжүүлэлт
Эрсдэлийн удирдлага

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

1. АПУ ГРУПП КОМПАНИЙН БҮРЭЛДЭХҮҮНД БУЙ 4 КОМПАНИ МОНГОЛ УЛСЫН "ТОП 100 АЖ АХУЙН НЭГЖ"-ЭЭР ШАЛГАРЛАА

Улсын эдийн засгийн гол хөдөлгөгч хүч болж, татварын орлогыг бүрдүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулж буй ТОП-100 аж ахуй нэгжийг Монгол Улсын Засгийн газар, Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимаас жил бүр алдаршуулдаг хүндэтгэлийн үйл ажиллагаа 24 дэх жилдээ зохион байгуулагдлаа.

Тус жагсаалтад АПУ ХК 22 дахь жилдээ шалгарсан бол АПУ Трейдинг ХХК, Спирт Бал Бурам ХХК, АПУ Дэйри ХХК тус тус шалгарлаа.



2. АПУ ХК БОЛОН АПУ ДЭЙРИ КОМПАНИ 2025 ОНЫ МОНГОЛ УЛСЫН ШИЛДЭГ ТАТВАР ТӨЛӨГЧӨӨР ТОДОРЛОО

Монголын татварын алба 26 дахь жилдээ “Татвар төлөгчдийн өдрүүд”-ийг зохион байгуулсан билээ.

2024 онд АПУ компани нь улс, орон нутгийн төсөвт нийт 474 тэрбум буюу өдөрт 1.3 тэрбум төгрөгийн татварын орлого оруулснаар “ТАТВАР ТӨЛӨЛТӨӨРӨӨ ТЭРГҮҮЛЭГЧ - 10” аж ахуйн нэгжээр шалгарлаа.

АПУ Дэйри Монгол сүүний үйлдвэр нь “ТОМ СЕГМЕНТИЙН ШИЛДЭГ ТАТВАР ТӨЛӨГЧ” аж ахуйн нэгжээр тус тус шалгарлаа.



3. СЭНГҮР БРЭНД ИЛҮҮ ЗӨӨЛӨН, ШИНЭ АМТААР “ШИНЭЧЛЭЛ” ХИЙЛЭЭ

2007 оноос хойш Монголын шар айргийн зах зээлд зөөлөн амтаараа ялгарч, 17 жилийн турш ТОП сонголт болж ирсэн “Сэнгүр брэнд” цоо шинэ амт, өнгө төрхийг урлаж хэрэглэгчдэдээ хүргэлээ. Энэ шинэчлэлээр брэндийн үнэ цэн, өнгө төрх, амт чанар бүхий л түвшинд шинэ шатанд гарч илүү шинэлэг, илүү зөөлөн болж өөрчлөгдлөө.

Шар айргийн өндөр технологи, чанарын стандартыг Монголдоо мэргэжлийн өндөр түвшинд хөгжүүлэх нь бидний тэргүүн зорилтуудын нэг байж ирсэн бөгөөд хамгийн шинэ, супер чанарыг Монголоосоо мэдрэх боломжийг хэрэглэгчдэдээ олгож байна.

СЭНГҮР брэндийн 2025 оны шинэчлэлийн ажилд Дэлхийд тэргүүлэх дизайны агентлагууд болох Австрали улсын “Boldinc”, Франц улсын “Dragon Rouge”, Нидерланд улсад төвтэй “Design Bridge” нартай хамтран ажилласан.

Мөн шинэчлэлийнхээ хүрээнд урт хугацаанд хамтран ажилласан 200 шилдэг харилцагчдадаа ШИНЭ ХӨРГӨГЧ, 1500 харилцагчид ГАРЫН БЭЛЭГ хүргүүлж талархлаа илэрхийллээ.



4. АПУ КОМПАНИЙН БРЭНДҮҮД ДЭЛХИЙД ЧАНАРААР ҮНЭЛЭГДЛЭЭ

Бельгийн нийслэл Брюссельд байрлах Олон улсын чанар, стандартыг тодорхойлогч “Monde Selection” институт нь 1961 оноос эхлэлтэй бөгөөд спирт, архи, шар айраг, хийжүүлсэн ус, цэвэр ус, хүнсний бүтээгдэхүүн, эрүүл мэндийг дэмжих хүнсний нэмэлт бүтээгдэхүүний чанарыг тодорхойлдгоороо дэлхийд алдартай.

Monde Selection-ий шалгуур үзүүлэлтэд бүтээгдэхүүний загвар, үнэр, амт, сав баглаа боодол болон олон нийтийн үнэлгээ гэсэн үзүүлэлтүүд ордог бөгөөд хамгийн дээд оноо цуглуулж чадсан бүтээгдэхүүнүүдэд 4 төрлийн чанарын шагнал олгодог.

Ийнхүү олон улсын чанар, стандартын хүрээлэнгийн бие даасан мэргэжилтнүүд болох их сургуулийн профессорууд, хүнсний инженерүүд, мэргэжлийн амт шалгагчид АПУ ХК-ийн бүтээгдэхүүнүүдийн амтыг мэдэрч, “дээд зэрэглэлийн чанартай” хэмээн дахин үнэллээ.

2025 оны шалгаруулалтад Монгол Улсаас үндэсний үйлдвэрлэгч АПУ ХК-ийн “Blue Mark”, “Kharaa”, “Seruun”, “Ginger Ale” брэндүүд “Gold winning awards” шагнал хүртлээ. Ийнхүү Европын болоод дэлхийн шингэн хүнсний зах зээлд хамгийн өндөр чанар, стандартыг хангасан бүтээгдэхүүнээр АПУ ХК-ийн бүтээгдэхүүнүүд дахин нэрлэгдлээ.



5. ФРАНЦЫН ЗАХ ЗЭЭЛД ХУДАЛДААЛАГДАЖ ЭХЭЛЛЭЭ

2025 оны 5-р сараас эхлэн АПУ ХК нь Францын хамгийн нэр хүндтэй дарс, ликёрын сүлжээ болох Nicolas дэлгүүр мөн Европын хамгийн том цахим худалдааны платформ болох Vinatis-д Chinggis Khan, Soyombo болон Chinggis Grandkhaan брэндүүдээ албан ёсоор худалдаалж эхэлсэн.

Францын 'Nicolas' сүлжээ төрөлжсөн дэлгүүрээр дамжуулан бид зөвхөн үндэсний бахархал болсон брэнд бүтээгдэхүүнүүдээ хэрэглэгчдэд таниулахаас гадна Монголын өв соёл, үнэт зүйлсийг дэлхийд түгээж байна. Ийнхүү чанар, стандартын өндөр шаардлагатай, өрсөлдөөн ихтэй зах зээлд Монголын брэндүүд амжилттай нэвтэрч, дэлхийн тансаг хэрэглээний шинэ хэмжүүрт хүрч буй нь манай үндэсний брэндийн үнэлэмж, чанар дэлхийд хүлээн зөвшөөрөгдөж буйн тод илрэл юм.



6. ЧИНГИС ХААН БРЭНД ИТАЛИ УЛСАД...

Итали улсын Ром хотын зүрхэн дэх "World's 50 Best Bars" жарсаалтад 33-р байранд орсон Nite Kong ресторанд Чингис Хаан брэнд Мишелин одтой (Michelin-starred) тогооч Фабио Веррелли (Fabio Verrelli) мөн алдарт олон улсын миксологич Патрик Пистолези (Patrick Pistolessi) нарын гайхамшигт амт, мэдрэмжийн төгс зохицлыг цогцлоож шинэ мэдрэмжүүдийг хөглөлөө.



7. АЛТАН ГОВЬ ШАР АЙРАГ MART24 СҮЛЖЭЭ ДЭЛГҮҮРҮҮДЭЭР АЛБАН ЁСООР ХУДАЛДААЛАГДАЖ ЭХЭЛЛЭЭ

2025 оны 5-р сарын 1-ний өдрөөс эхлэн Алтан Говь брэнд нь Өмнөд Солонгос улсын хэмжээнд 8,000 гаруй салбартай emart24 сүлжээгээр дамжин Солонгосын хэрэглэгчдэд илүү өргөн хүрээгээр хүрэх боломжтой болж байна. Тус шар айргийг 2022 оноос хойш Өмнөд Солонгосын хамгийн том ая тухтай дэлгүүрийн нэг GS25-ын 13,000 гаруй салбарт тогтмол худалдаалж ирсэн. Энэхүү тэлэлт нь зөвхөн нэг брэндийн амжилт бус Монголын шар айраг үйлдвэрлэл олон улсын зах зээлд чанараараа үнэлэгдэж, тогтвортой байр суурь эзэлж буйн бодит илрэл болж байна.



8. ДЭЛХИЙН ХАМГИЙН ТОМ ШИНГЭН ХҮНСНИЙ ОЛОН УЛСЫН ҮЗЭСГЭЛЭНД 2 ДАХЬ УДААГАА МОНГОЛ УЛСАА ТӨЛӨӨЛӨН ОРОЛЦОВ



ХБНГУ-ын Дюссельдорф хотноо зохион байгуулагдсан дэлхийн хамгийн том шингэн хүнсний олон улсын үзэсгэлэн болох Prowein 2025-д Монгол Улсаа төлөөлж 2 дахь удаагаа CHINGGIS KHAN брэндээр малгайлан оролцлоо.

2023 онд Prowein үзэсгэлэнд 65 улсын 5,764 компани оролцсон бөгөөд 148 улсын 50,000 гаруй зочид хүрэлцэн ирсэн тоо баримт бий. Энэхүү үзэсгэлэн хэрэглэгч харилцагч нарыг холбодог хамгийн том гүүр юм.

2025 онд АПУ компани үндэсний брэнд бүтээгдэхүүнээ олон улсад таниулах зорилгоор Chinggis Khan, Soyombo, Chinggis Grand Khan, Eden брэндүүдээ дэлхийн хэрэглэгчдэд танилцуулан, Монгол Улсаа сурталчлах их ажлыг үргэлжлүүлсээр байна.



9. “(CHINA) EURASIA COMMODITY AND TRADE EXPO 2025” ҮЗЭСГЭЛЭНД АМЖИЛТТАЙ ОРОЛЦЛОО

БНХАУ-ын Өрөмч хотод зохион байгуулагдсан үзэсгэлэнд амжилттай оролцлоо. Тус үзэсгэлэнд 50 гаруй орны 2800 гаруй компани оролцон өөрсдийн бараа бүтээгдэхүүн, үйл ажиллагааг сурталчлан танилцуулсан юм. АПУ ХК-ийн хувьд экспортын шилдэг бүтээгдэхүүнүүдээ танилцуулж Монгол эх орныхоо нэрийн хуудас болон амжилттай оролцлоо.



10. “АПУ ДЭЙРИ МОНГОЛ СҮҮНИЙ ҮЙЛДВЭР” СҮҮ ХАНГАН НИЙЛҮҮЛЭГЧ МАЛЧИД, ФЕРМЕРҮҮДИЙН БОДИТ ОРЛОГЫГ НЭМЭГДҮҮЛЖ, МЕНЕЖМЕНТИЙГ ОНОВЧЛОХ ШИНЭ ТҮНШЛЭЛ ЭХЛҮҮЛЛЭЭ

Монгол хүний эрүүл мэндийг тэтгэх сүүний хэрэглээг 3 дахин нэмэгдүүлэх зорилгын хүрээнд АПУ Дэйри Монгол сүүний үйлдвэр нь Хүнс Хөдөө Аж Ахуй Хөнгөн Үйлдвэрийн Яам, Хаан банк, Монголын Тогтвортой Санхүүжилтийн Холбоо, Сүүний салбарыг хөгжүүлэх үндэсний зөвлөлтэй хамтран сүүний фермерүүд болон малчид, тариалан эрхлэгчдэд хамтын өгөөжтэй бодлого, хөрөнгө оруулалт, чанар, стандартыг мэргэжлийн түвшинд хүргэх цогц хамтын ажиллагааг эхлүүллээ.

АПУ Дэйри компани нь дэлхийн шилдэг, сүүний хөгжлийн гол тоглогч Илли компанийн Хар тарлан буюу Холстейн үүлдрийн сүүний өндөр гарцтай эрчимжсэн үхрийг сүү нийлүүлэгч малчид, фермерүүдэд хөнгөлөлттэй нөхцөлөөр нийлүүлэх бөгөөд зөвхөн эрчимжсэн үхэр нийлүүлээд зогсохгүй тэжээлийн жор орц, техник тоног төхөөрөмжийн шилдэг шийдлүүд, үхрийн эрүүл мэнд, үржлийн менежментийн чиглэлээр Монголд тохирох аргыг олон улсын мэргэжлийн багийн хамтаар боловсруулж, нутагшуулахаар болсон нь олон улсын шилдэг туршлага, менежмент, стандартыг цогцоор нь эрчимжсэн мал аж ахуйд нэвтрүүлэх эдийн засгийн өндөр өгөөжтэй чухал алхам болж байна.

Түншлэлийн хүрээнд үлгэр жишээ, өндөр бүтээмж, ашигтай сүүний фермийн тогтолцоог богино хугацаанд хөгжүүлэхээр зорьж байгаа ба цаашид “Сүүний төв станц” бүхий томоохон хэмжээний нэгдэл хамтран хөгжүүлэх шийдэл боловсруулж орон нутагт өндөр орлоготой, чинээлэг малчид, тариаланчдыг бий болгож хамтын оролцоог чухалчилсан цогц ажил хийхээр урт хугацааны зорилгоо тодорхойлж байна.



11. "ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ"-НЫ 100 ЖИЛИЙН ОЙ

"Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам"-ны 100 жилийн ойн хүрээнд зохион байгуулагдаж буй Үндэсний үйлдвэрлэгчдийн үзэсгэлэн худалдаанд АПУ компани болон АПУ ДЭЙРИ - Монгол сүүний үйлдвэр хамтран оролцлоо.



12. АПУ ДЭЙРИ — МОНГОЛ СҮҮНИЙ ҮЙЛДВЭР НЬ ОЛОН УЛСЫН АМТ, ЧАНАРЫН ӨНДӨР ШАЛГУУРТАЙ “SUPERIOR TASTE AWARD 2025” ШАГНАЛЫН ЭЗЭН БОЛЛОО

Энэхүү шагнал нь International Taste Institute-ээс дэлхийн 200 гаруй шилдэг шүүгч мэргэжилтнүүд хараат бус, мэргэжлийн түвшинд үнэлэн олгодог хүнсний салбарын нэр хүндтэй шагнал юм.

Шагнал хүртсэн брэнд бүтээгдэхүүнүүд:

- Pro+ брэнд | Болгар тарваг
- Pro+ | Healthy Milk
- Mont-Yak брэнд | Шар тос Дэлхийд шалгарсан Монгол амт!



13. ҮЙЛДВЭРИЙН ХАЯГДАЛ УС ЦЭВЭРЛЭХ БАЙГУУЛАМЖИЙН ТӨСЛИЙН ШАВ ТАВИХ ЁСЛОЛ

Уг төслийн хүрээнд компанийн үндсэн үйлдвэрүүд болох төв АПУ үйлдвэр, АПУ Дэйри ХХК, Натур Агро спиртийн үйлдвэр, М Би Си Азия Пасифик ХХК-ийн хаягдал усыг дахин боловсруулан ашиглах олон улсын жишигт нийцсэн цэвэрлэх байгууламжийг байгуулж байна. Уг төсөл нь нийтдээ 45 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт бүхий томоохон цар хүрээтэй төсөл болж байна. Цэвэрлэх байгууламжийг хоногт 2800 м³ бохир ус цэвэрлэх хүчин чадалтай хамгийн сүүлийн үеийн стандарт, дэвшилтэт технологийг ашиглахаар төлөвлөсөн.

Тус төсөл хэрэгжсэнээр Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийн ачааллыг бууруулах, Туул голын усны чанарыг хамгаалах, улмаар байгаль орчны тэнцвэртэй байдлыг хадгалахад нэн чухал үүрэг гүйцэтгэж байгаагаараа давуу талтай. Мөн АПУ ХК нь энэ төслийн хүрээнд төвлөрсөн хаягдал ус цэвэрлэх концепцийн дагуу ажиллаж байгаа бөгөөд дараа дараагийн төслүүддээ ч бие даасан цэвэрлэх байгууламжийг барих бодлого баримталж байна.



14. ЖЭЙ СИ АЙ (JCI) БАЙГУУЛЛАГЫН АЗИ, НОМХОН ДАЛАЙН БҮСИЙН ЧУУЛГА УУЛЗАЛТ "2025 JCI ASIA PACIFIC CONFERENCE"-ЫН ЕРӨНХИЙ ИВЭЭН ТЭТГЭГЧЭЭР ХАМТРАН АЖИЛЛАЛАА

Энэхүү арга хэмжээ нь залуучуудын манлайллын чадварыг нэмэгдүүлэх, дэлхийн өнцөг булан бүрээс ирсэн шилдэг мэргэжилтнүүдтэй хамтран ажиллах гайхалтай боломжийг олгодгоороо давуу талтай.


Тус арга хэмжээнд 70 гаруй орны 5,000 орчим оролцогчид оролцсон бөгөөд зөвхөн салбарын чуулган байхаас илүү аялал жуулчлал, тээвэр, худалдаа, үйлдвэрлэл гэх мэт олон салбарт богино хугацаанд үр өгөөж өгөхөөр зорин ажилласан билээ.

Чуулганы хүрээнд хөгжингүй орнуудын бизнесийн төлөөлөл Монгол Улсад ирж, харилцаа, түншлэл эхлүүлэх зэрэг олон талт боломжууд бүрдэх бөгөөд Монгол Улс руу чиглэсэн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, олон улсын зах зээлд байр сууриа өсгөх ач холбогдолтой олон улсын анхаарал татсан арга хэмжээ байлаа.



15. “ХАМТДАА” ХАРИЛЦАГЧДЫН БИЗНЕС ӨДӨРЛӨГ

АПУ компани аялал жуулчлалын салбарт, тэр дундаа Амралтын газар, Жуулчны баазын бизнес эрхлэгч харилцагчдын төлөөллүүдтэй хамтын ажиллагаагаа бэхжүүлэх, өргөжүүлэн тэлэх зорилгоор “Хамтдаа” харилцагчдын бизнес өдөрлөгийг 3 дахь удаагаа амжилттай зохион байгууллаа. Бизнес өдөрлөгөөр АПУ компанийн аялал жуулчлалын салбарт баримталж буй бодлого, шинэ брэнд бүтээгдэхүүнүүд, тэр тусмаа шинэчилсэн Сэнгүр брэндийн танилцуулга, 2025 оны аялал жуулчлалын улирлын хамтын ажиллагааны төсөл хөтөлбөрүүдийг танилцуулсан ажил хэрэгч өдөрлөг болж өнгөрлөө.



САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАН

		2024 II улирал Аудитлагдаагүй	2025 II улирал Аудитлагдаагүй
Эргэлтийн хөрөнгө	сая.төг	516,443.42	634,364.20
Эргэлтийн бус хөрөнгө	сая.төг	553,987.11	608,477.73
Нийт хөрөнгө	сая.төг	1,070,430.53	1,242,841.93
Өр төлбөр	сая.төг	328,622.69	387,596.31
Эздийн өмч	сая.төг	741,807.84	855,245.62
Нийт өр төлбөр ба Эздийн өмч	сая.төг	1,070,430.53	1,242,841.93

ОРЛОГО ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

		2024 II улирал Аудитлагдаагүй	2025 II улирал Аудитлагдаагүй
Борлуулалтын орлого (цэвэр)	сая.төг	649,401.7	652,534.7
Борлуулалтын өртөг	сая.төг	336,965.2	330,236.2
Нийт ашиг (алдагдал)	сая.төг	312,436.6	322,298.5
Үйл ажиллагааны зардал	сая.төг	173,511.1	197,147.3
Үйл ажиллагааны ашиг	сая.төг	138,925.5	125,151.3
Үйл ажиллагааны бус ашиг, алдагдал	сая.төг	716.9	2,612.5
Татварын өмнөх ашиг	сая.төг	139,642.3	127,763.8
Орлогын албан татварын зардал	сая.төг	31,743.1	30,117.7
Татварын дараахь ашиг (алдагдал)	сая.төг	107,899.2	97,646.1
		2024 II улирал	2025 II улирал
Үйл ажиллагааны маржин		21%	19%
Цэвэр ашгийн маржин		17%	15%

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХУРААНГУЙ

Борлуулалтын тоо хэмжээ
сая.литр



Цэвэр борлуулалтын орлого
тэрбум.төгрөг



Үйл ажиллагааны ашиг
тэрбум.төгрөг



Цэвэр ашиг
тэрбум.төгрөг



Хөрөнгө оруулалт
тэрбум.төгрөг



Татвар төлөлт
тэрбум.төгрөг



БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ТӨРӨЛ
SKU



2024.VI



2025.VI

АЖИЛЧДЫН ТОО



2024.VI



2025.VI

ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН БАГ



Цэвээнжавын
ЭРДЭНЭБИЛЭГ
Гүйцэтгэх захирал



Гончигийн
ЭНХБИЛЭГ
Санхүү эрхэлсэн захирал,
Төслийн удирдлагын захирал



Батсайханы
ЦАЦРАЛ
Борлуулалт, маркетинг
эрхэлсэн захирал



Жаргалсайханы
ИЧИНХОРЛОО
Захиргаа, Хүний нөөц
эрхэлсэн захирал



Галсумьяагийн
БАЯРМАГНАЙ
АПУ Дэйри ХХК-ийн Гүйцэтгэх
захирал




Онг
АЛЛАН
Дижитал шилжилт, өөрчлөлт
эрхэлсэн захирал



Заховал
АЛЕШ
Үйлдвэрлэл, үйл ажиллагаа
эрхэлсэн захирал

БҮТЭЭГДЭХҮҮН ХӨГЖҮҮЛЭЛТ



ШАР АЙРГИЙН ТӨРӨЛ ДЭЭР ХИЙГДСЭН ШИНЭЧЛЭЛТИЙН АЖЛУУД

- **Sengur Брэндийн Шинэчлэл** – Sengur брэндийг цогцоор нь шинэчилж, зах зээлд нэвтрүүлсэн. Шинэчлэлийн хүрээнд Үндсэн “Sengur”, “Sengur White” залуучууд руу чиглэсэн шинэ төрөл болох “Sengur Ultra” брэндүүдийг зах зээлд нэвтрүүлсэн.
- **Sengur Ultra** – Залуу үеийнхэн рүү чиглэсэн шинэлэг загвар дизайнтай, зөөлөн амттай Sengur Ultra брэндийг 500мл лаазтай савлагаатайгаар зах зээлд нэвтрүүлсэн. 7 сарын дунд үеэс шилтэй савлагааг гаргахаар төлөвлөн ажиллаж байна.
- **Sengur Aluminium савалгаа** – “Sengur” брэндийн Aluminium савлагаатай дээд зэргийн төрлийг зах зээлд нэвтрүүлсэн.

ЦАГААН АРХИНЫ ТӨРӨЛ ДЭЭР ХИЙГДСЭН ШИНЭЧЛЭЛТИЙН АЖЛУУД

- **Цагаан сарын баярт зориулан хийсэн ажлууд:** Цагаан сарын баярт зориулан цагаан архины 5 брэндэд уламжлалт баярын шинж байдлыг шингээсэн хайрцаг хийнэ худалдаанд гаргасан.
- **Agar Woody** – Agar брэндийн вискиний амттай шинэ төрлийг зах зээлд нэвтрүүлсэн.
- **WI сөжү** – WI сөжүний шинэ амттай 2 төрлийг зах зээлд нэвтрүүлсэн.
- **Kharaa брэндийн шинэчлэл:** “Kharaa” брэндийг цогцоор нь бүрэн шинэчилж зах зээлд нэвтрүүлсэн.

АЛКОХОЛЬ АГУУЛААГҮЙ ШИНГЭН ХҮНСНИЙ ТӨРӨЛ ДЭЭР ХИЙГДСЭН ШИНЭЧЛЭЛТИЙН АЖЛУУД

- **Оргилуун брэндийн шинэчлэл:** Оргилуун брэндийг цогцоор бүрэн шинэчилж, хосолсон жимсний амттайгаар зах зээлд нэвтрүүлсэн.
- **Оргилуун брэндийн шинэ төрөл:** Оргилуун Zero цитрус (Calamansi) жимсний амттай төрлийг зах зээлд нэвтрүүлсэн.
- **Тэрэлж&Сэлэнгэ брэндийн шинэчлэл:** Тэрэлж&Сэлэнгэ брэндийн загвар дизайн шинэчлэгдэн, шинэлэг өнгө төрхтэйгөөр зах зээлд нэвтэрсэн.
- **Тэрэлж&Сэлэнгэ шинэ төрөл:** Тэрэлж&Сэлэнгэ брэндийн шинэ төрөл болох интоорын амттай “Terelj Cherry” төрлийг зах зээлд нэвтрүүлсэн.

ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

2025 онд АПУ ХК нь тогтвортой хөгжлийн зарчмуудыг хэрэгжүүлэх, компанийн үнэ цэнийг хамгаалах, үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах зорилгоор эрсдэлийн удирдлагын бодлогыг баримталж ажилладаг.

Эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэхэд соёлыг түгээх, үнэ цэнийг бүтээх, шийдвэр гаргалтад ашиглагдах, ил тод мэдээллийн эх үүсвэртэй байх, тасралтгүй тогтвортой байх зэрэг зарчмуудыг баримталж ажилладаг.

Бизнесийн тогтвортой үйл ажиллагааг хангах зорилготойгоор 2025 оны эхний хагас жилд АПУ ХК-ийн бүх байршлуудад олон улсын стандартын дагуу хөрөнгийн эрсдэлийн үнэлгээг эхлүүлсэн. Тус эрсдэлийн үнэлгээ нь компанийн хөрөнгө оруулалтуудын шийдвэр гаргалтад ашиглаж, аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх, процессуудыг сайжруулах санал санаачилгыг хэрэгжүүлэх замаар бизнесийн үнэ цэнийг бэхжүүлж, тасралтгүй хөгжиж дэвжих соёлыг түгээх зорилготой болно.

Мөн тогтвортой хөгжлийн зарчим, чиг хадлагад нийцүүлэн саарал ус боловсруулах үйлдвэр болон сүүний үйлдвэрийн өргөжилтийн төслүүдийг хэрэгжүүлж байна.

Үйлдвэрийн хаягдал ус цэвэрлэх байгууламжийн төсөл нь MNS-6734-2025 буюу дахин ашиглах цэвэрлэсэн усны стандартыг хангаж, экологийг тогтвортой байдлыг хангах, усны нөөцийн оновчтой хэрэглээнд эерэг нөлөөллийг бий болгох зорилготойгоор шат дараатайгаар хэрэгжүүлж байна.

Мөн сүүний үйлдвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлэх өргөжүүлэх төсөл нь 2025 онд хэрэгжиж эхэлсэн томоохон хөрөнгө оруулалттай ажлын нэг болно. Энэхүү төслийн хүрээнд 40 сая ам.долларын тэнцэхүйц санхүүжилтийг татан төвлөрүүлж, сүү сүүн бүтээгдэхүүн боловсруулах хүчин чадлыг нэмэгдүүлэхэд чиглэсэн бүтээн байгуулалт хэрэгжүүлж байна. Мөн дотоодын түүхий эд нийлүүлэлтийн сүлжээг тогтвортой болгох зорилготойгоор Нэгдсэн үндэсний байгууллагатай хамтран сургалт, зөвлөгөөг олгож, эрчимжсэн кластер ферм байгуулах зорилготойгоор дотоодын арилжааны банкуудтай хамтран малчин өрхүүд болон фермерүүдэд хөдөө аж ахуйн хөрөнгө оруулалтын зээл олгосон.

Түүнчлэн 2025 онд компанийн үйл ажиллагаатай холбоотой хүлэмжийн хийн ялгарлыг тооцоолох, багасгах ажлыг илүү системтэй болгож эхэлсэн. CO2 тооцооллын анхны суурь мэдээлэл цуглуулж, тооцоолол, тайланг гаргасан. Энэ нь зөвхөн байгаль орчны эрсдэлийг бууруулах бус, эрчим хүчний зардлыг бууруулах, хариуцлагатай үйлдвэрлэлд шилжих чухал алхам байлаа.

Эдгээр томоохон төслүүд болон бизнесийн дотоод үйл ажиллагаандаа ашиглаж буй эрсдэлийн удирдлагын программаар дамжуулан аливаа учирч болзошгүй эрсдэл, тодорхойгүй байдлыг урт болон богино хугацаандаа оновчтой удирдахад туслах юм.

Мөн манай салбарын болон компанийн үйл ажиллагаанд шууд болон шууд бус байдлаар нөлөөлөх томоохон эрсдэлүүдийг бид тооцоолж тодорхойлсон ба эдгээрээс хамгийн өндөр ач холбогдолтой гэдгээр нь голлох 4 эрсдэлийг онцоллоо.

БИДНИЙ ТУХАЙ

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХУРААНГУЙ

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ

Түүхий эд, бараа материалын ханган нийлүүлэлт

- Импортын бараа бүтээгдэхүүний үнийн өсөлт
- Логистикийн үйл ажиллагаа

Эрчим хүчний хангамж ба тогтвортой байдал

- Хэрэглээний хязгаарлалт
- Эрчим хүч, дулааны үнийн өсөлт

Эдийн засгийн нөхцөл байдал

- Гадаад валютын ханшийн хөдөлгөөн
- Инфляци
- Хэрэглэгчийн худалдан авах чадамж

Хөдөлмөрийн зах зээл

- Ажиллах хүчний тогтвортой байдал
- Мэргэшсэн ажиллах хүчний хомсдол

A couple, a man and a woman, are standing and looking up at a vibrant sunset sky. The sky is filled with soft, colorful clouds in shades of blue, purple, and pink. The couple is silhouetted against the bright light of the setting sun. A large, white, stylized number '3' is overlaid on the left side of the image, partially obscuring the couple and the sky.

3

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

АПУ Групп компанийн бүтэц
Хувьцаа эзэмшигчдийн хурал
Хувьцаа эзэмшигчдийн бүтэц
Төлөөлөн Удирдах зөвлөл
Ногдол ашгийн мэдээлэл
Компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийн өөрийн үнэлгээ
Хувьцааны арилжааны мэдээлэл

АПУ ГРУПП КОМПАНИЙН БҮТЭЦ



*2025 онд АПУ Групп компанийн бүтцэд өөрчлөлт ороогүй.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ

АПУ ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал цахим хэлбэрээр 2025 оны 04 сарын 24-ний өдрийн 14:00-15:17 цагийн хооронд 87.91%-ийн ирцтэй хуралдаж дараах шийдвэрийг гаргав:

1. АПУ ХК-ийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан “АПУ групп компани 2024 онд тавьсан зорилтуудаа биелүүлж, амжилттай ажилласан” гэсэн дүгнэлтийг батлав.
2. АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшууллыг ТУЗ-ийн дарга 10 сая, ТУЗ-ийн гишүүд 6.5 сая байхаар батлав.



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН БҮТЭЦ



Өнгөрөгч оны мөн үетэй харьцуулбал нөлөө бүхий хувьцаа эзэмшигч Шунхлай холдинг ХХК-ийн эзэмшлийн хувь 0.6%-аар нэмэгдэж, Steppe Beverage KFT-ийн эзэмшлийн хувь 0.11%-аар буурсан байна.


ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

Хувьцаа эзэмшигчдийн 2024 оны 04 сарын 30-ны өдрийн ээлжит хурлаар 3 жилийн хугацаатай сонгосон ТУЗ-ийн бүрэлдэхүүнд өөрчлөлт ороогүй.

ТУЗ-ийн бүрэлдэхүүн



ПҮРЭВИЙН БАТСАЙХАН
ТУЗ-ийн ердийн гишүүн бөгөөд
ТУЗ-ийн дарга
Инженер мэргэжилтэй
Шунхлай холдинг ХХК-ийн Ерөнхийлөгч
2002 оноос хойш АПУ ХК-ийн ТУЗ-ийн дарга
Хувьцаа эзэмшил:
Хувь хүн: 91,647 ширхэг (0.01%)
Шунхлай холдинг ХХК: 602,651,260 ширхэг (56.63%)



БҮРЭНТОГТОХЫН БАТБАЯР
ТУЗ-ийн ердийн гишүүн
Эдийн засагч мэргэжилтэй
Шунхлай холдинг ХХК-ийн Гүйцэтгэх дэд ерөнхийлөгч
2013 оноос хойш АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүн
Хувьцаа эзэмшил:
Хувь хүн: 82,267 ширхэг (0.01%)
Шунхлай холдинг ХХК: 602,651,260 ширхэг (56.63%)




КЕННЕТ ЧУ
ТУЗ-ийн ердийн гишүүн
Няглан бодогч, менежмент мэргэжилтэй
Хайнекен Азия Пасифик компанийн Ази-Номхон далайн бүсийг хариуцсан Гүйцэтгэх захирал
2018 оноос хойш АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүн
Хувьцаа эзэмшил:
Хувь хүн: 0 ширхэг (0.00%)
Хайнекен Азия Пасифик Пте Лтд: 266,091,981 ширхэг (25.00%)



СЭН И-ИН
ТУЗ-ийн ердийн гишүүн
Хуульч мэргэжилтэй
Хайнекен Азия Пасифик компанийн Ази-Номхон далайн бүсийн Хууль эрхзүй хариуцсан захирал
2020 оноос хойш АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүн
Хувьцаа эзэмшил:
Хувь хүн: 0 ширхэг (0.00%)
Хайнекен Азия Пасифик Пте Лтд: 266,091,981 ширхэг (25.00%)



БАТСАЙХАНЫ ГАНТИГ
ТУЗ-ийн ердийн гишүүн
Бизнесийн удирдлага, менежмент мэргэжилтэй
Шунхлай холдинг ХХК-ийн Стратеги хариуцсан захирал
Дижитал концепт ХХК-ийн Гүйцэтгэх захирал
2024 оноос хойш АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүн
Хувьцаа эзэмшил:
Хувь хүн: 1,000 ширхэг (0.00%)
Шунхлай холдинг ХХК: 602,651,260 ширхэг (56.63%)



БАЯРЦОГТЫН ГОМБО-ЭРДЭНЭ
ТУЗ-ийн ердийн гишүүн
Хэрэглээний математикч, эдийн засагч, санхүүч мэргэжилтэй
Шунхлай холдинг ХХК-ийн Бизнес хөгжил хариуцсан захирал
2024 оноос хойш АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүн
Хувьцаа эзэмшил:
Хувь хүн: 100 ширхэг (0.00%)
Шунхлай холдинг ХХК: 602,651,260 ширхэг (56.63%)



Одончимэдийн ОДБАЯР
ТУЗ-ийн хараат бус гишүүн
Багш, эрх зүйн мэргэжилтэй
Ард даатгал ХК, Ард холдинг ХХК, Монгол шуудан ХК-уудын ТУЗ-ийн гишүүн
2021 оноос хойш АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүн
Хувьцаа эзэмшил: 0 ширхэг (0.00%)



ЖИГЖИДИЙН ҮНЭНБАТ
ТУЗ-ийн хараат бус гишүүн
Эдийн засагч мэргэжилтэй
2013 оноос хойш АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүн
Хувьцаа эзэмшил: 0 ширхэг (0.00%)



ЁНДОН-ОЙДОВЫН ГЭРЭЛЧУЛУУН
ТУЗ-ийн хараат бус гишүүн
Эдийн засагч мэргэжилтэй
Нээлттэй хот ТББ-ын үүсгэн байгуулагч
2017 оноос хойш АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүн
Хувьцаа эзэмшил: 0 ширхэг (0.00%)

НОГДОЛ АШГИЙН МЭДЭЭЛЭЛ


ТУЗ-ийн 2025 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 25/02 тоот тогтоолоор 2024 оны хоёрдугаар хагас жилийн санхүүгийн үр дүнг харгалзан нэгж хувьцаанд ₮65 (жаран таван төгрөг)-ийн ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн.

Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалт гарах бүртгэлийн өдрийг 2025 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдөр (2025 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр)-өөр тогтоож, ногдол ашгийг 2025 оны 08 дугаар сарын 19-ний өдрийн дотор төлөхөөр тогтлоо.

Тус ногдол ашгийн төлбөрийг нийт хувьцааны таваас доош хувийг эзэмшигчдэд “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-аар зуучлуулан 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр хувьцаа эзэмшигчдийн төвлөрсөн хадгаламжийн дансанд байршуулсан ба таваас дээш хувийг эзэмшигчдэд компаниас шууд төлөх замаар мөнгөн хэлбэрээр олгов.

НОГДОЛ АШГИЙН ХУВААРИЛАЛТ

НЭГЖ ХУВЬЦААНД ЗАРЛАСАН НОГДОЛ АШГИЙН ХЭМЖЭЭ БОЛОН ӨГӨӨЖ ТӨГРӨГӨӨР, ХУВИАР




КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКСИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ӨӨРИЙН ҮНЭЛГЭЭ

АПУ ХК-ийн 2024 оны нэгдүгээр хагас жилийн компанийн засаглалын өөрийн үнэлгээний тайлангаар нийт 72 онооноос 71 оноо буюу 98.6%-аар үнэлснээр “засаглал хэвийн буюу эрсдэлгүй” түвшинд үнэлэгдлээ.

Д/	Гарчиг	Авбал зохих нийт оноо	Үнэлсэн оноо	Үнэлгээний хувь
д	ТУЗ-ийн бүтэц, зохион байгуулалт	12	12	100%
1	ТУЗ-ийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэг	10	10	100%
2	Тайлагнал, мэдээллийн ил тод, байдал	6	6	100%
3	Аудит, хяналтын тогтолцоо	6	6	100%
4	Эрсдэлийн удирдлага	8	8	100%
5	Эрх бүхий албан тушаалтны цалин урамшуулал	6	6	100%
6	Оролцогч талуудын эрх ашиг	8	8	100%
7	Компанийн соёл	6	6	100%
8	Хувьцаа эзэмшигчдийн эрх	10	9	90%
9	Нэгдсэн дүн	72	71	98.6%

ХУВЬЦААНЫ МЭДЭЭЛЭЛ

АПУ ХК-ийн хувьцааны хаалтын ханш оны эхэнд ₮999.51 байсан бол хагас жилийн эцэст ₮968.18 болж буурсан байна.



АПУ компанийн зах зээлийн үнэлгээ 1.03 их наяд төгрөг байгаа нь хувьцаат компаниудаас дөрөвдүгээр байранд орж байна.



04

ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ

Ямагт орших өв соёл
Ногоон ба цэвэр тунгалаг
Хүчирхэгжсэн хамт олон
Баялаг хариуцлагатай
Тогтвортой түнш

АПУ ХК-ийн “Бахархалт Монгол” тогтвортой хөгжлийн стратегийн таван баганын хүрээнд 2025 оны эхний хагас жилд доорх ажлуудыг хэрэгжүүлэв.

ЯМАГТ ОРШИХ ӨВ СОЁЛ

“Европын сэргээн босголт, хөгжлийн банк - НҮБ-ын Хүнс, Хөдөө аж ахуйн байгууллага - АПУ Дэйри ХХК - Сүүний салбарыг хөгжүүлэх үндэсний зөвлөл ТББ нарын хамтарсан сургалт

3 жилийн хугацаанд 700 малчныг сургах зорилтын хүрээнд сургагч багш нарыг бэлтгэх, малчдыг сургах эхний сургалтууд амжилттай зохион байгуулав.



НОГООН, ЦЭВЭР ТУНГАЛАГ

1. 2024 оны тогтвортой хөгжлийн тайланд хүлэмжийн хийн ялгарлын тооцооллыг (Scope 1, 2, 3) анх удаа бүрэн хэмжээгээр хийж, гуравдагч этгээдээс баталгаажуулалт авч, нийтлэв.

2. 2025 онд өгөгдөл автоматжуулах ажлыг эхлүүлж, гараар бүртгэдэг дата мэдээллийг системд оруулах зорилготой ажиллаж эхэллээ.

3. “Өнгө Нэмье” ТББ-тай хамтран дотоод хог хаягдлын менежментийг сайжруулах ажлын хүрээнд савлалтын үйлдвэрийн 80 ажилтан, үйлчилгээний 15 ажилтанд хог хаягдлаа хэрхэн зөв ялгах талаар сургалт орж, хогийн савнууд дээрх стикер наалтуудыг шинэчиллээ.



ХҮЧИРХЭГЖСЭН ХАМТ ОЛОН

1. 2025 оны 3 дугаар сард үйл ажиллагааны зургаан байршилд Дэлхийн усны өдөр, Дэлхийн хүрээлэн буй орчны өдөр, Дэлхийн хог хаягдлын эсрэг өдөр зэргийг тохиолдуулан, ажилчдад зориулсан сургалт, үйл ажиллагааг зохион байгууллаа. Уг өдөрлөгт нийт 308 ажилтан танхимаар хамрагдлаа. Үүнд:

- АПУ Дэйри - 56
- Төв АПУ - 61
- Баруун агуулах - 35
- Спиртийн үйлдвэр - 36
- Зүүнхараа - 79
- Амгалан - 40



2. “Innov-Talent” инновацлаг ур чадварын тэтгэлэгт хөтөлбөрт 100 оюутан шалгаруулсан ба энэхүү хөтөлбөр нь Монголын чадварлаг оюутнуудыг дэмжиж, ирээдүйн шилдэг мэргэжилтнүүдийг бойжуулах зорилготойгоор хэрэгжүүлсэн юм. Тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдсан оюутнууддаа сургалтын төлбөрийн 2 сая төгрөгийн тэтгэлэг олгохоос гадна:

Мэргэжлийн дадлагаа ажлын бодит орчинд цалинтай хийв.

Хувь хүний болон мэргэжлийн ур чадвараа АПУ академийн сургалт, хувь хүний хөгжлийн NOVA LMS багцын сургалтуудад хамрагдуулсан.



Инновацлаг төслийг санаачлан, 10 багт хуваагдан өрсөлдөж шилдэг багтаа 10 сая төгрөгийн санхүүжилт олгож төслөө хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

Хөтөлбөрт хамрагдагсдын 70% эмэгтэй, 30% эрэгтэй оролцогч байсан бөгөөд сонгогдсон оюутнуудын суралцаж буй чиглэл:



3. Сагсан бөмбөгийн Үргэлж өөдөө лиг

“Үргэлж өөдөө” сагсан бөмбөгийн лигт 4-6-р сарыг дуустал нийт 3 сарын турш эрэгтэй 10 баг, эмэгтэй 5 баг нийт 160 гаруй тамирчин ажилтан оролцсон. Лигийн системийн хамгийн чухал нь тамирчдыг драфтын системээр багт хуваарилан, жил бүр нэг баг бус олон багт орж найз нөхдийн хүрээллээ тэлэх боломж олгодгоос гадна дүрмээр багийн тамирчин бүрийн талбай дээрх минутын доод хязгаарыг заасан нь хүртээмж, оролцоог маш сайн нэмэгдүүлж өгсөн. Мөн багууд компанийн брэндүүдийн нэрээр багаа нэрлэж оролцдог нь дотооддоо брэндийг таниулахад эерэг нөлөө үзүүлж байна.



4. Ажиллах таатай орчныг бүрдүүлэх чиглэлээр “Ажлын байрны тохируулга” ажил


АПУ ХК-ын ажлын байрны үнэлгээний дагуу ногоон үнэлгээтэй буюу хурдан тохируулга орох боломжтой 10 ажлын байранд тохируулгын ажлуудыг хийв. Тус ажлын хүрээнд:

- Мэдээллийн хүртээмж
- Хамт олны хүртээмж
- Ажлын байрны хүртээмж гэсэн 3 чиглэлээр тохируулгын ажлуудыг хийж гүйцэтгэв.

Тус ажлыг хийж гүйцэтгэснээр хөгжлийн бэрхшээлтэй иргэд ажил горилохоор ирэхэд тус хүний онцлогт тохирсон ажлын байрыг санал болгон ажиллуулах, ажиллах үед гарах хүндрэлүүдийг бууруулж, ажиллахад таатай орчин нөхцөл, хамт олны халуун дулаан уур амьсгалыг бүрдүүлж, бичиг баримт, хөдөлмөр хамгааллын зааварчилгааг цаг алдалгүй өгч байна.


БАЯЛАГ, ХАРИУЦЛАГАТАЙ

Бид спорт, эрүүл амьдралын хэв маягийг дэмжих ажлуудаа тогтвортой үргэлжлүүлж байна. “FC Ulaanbaatar” багтай хамтран ажиллахын зэрэгцээ, компани дотроо залууст эерэг хандлага, хамтын өрсөлдөөн, хөгжлийг түгээх зорилготой “Үргэлж өөдөө” цахим спортын лиг болон сагсан бөмбөгийн лигийг амжилттай зохион байгуулсаар байна.



ТОГТВОРТОЙ ТҮНШ

1. 2025 оны 2-р сард АПУ Дэйри ХХК-ийн тогтвортой хөгжлийн санаачилга нь Тогтвортой банк санхүүгийн сүлжээ (SBFN)-ийн албан ёсны вэб сайтад жишээ кейс хэлбэрээр нийтлэгдлээ. Уг нийтлэлд Монгол Улсын сүү, сүүн бүтээгдэхүүний салбарыг хөгжүүлэхэд АПУ Дэйри компанийн манлайлагч үүргийг онцолсон бөгөөд Европын Сэргээн босголт, хөгжлийн банк (EBRD), Азийн Хөгжлийн Банк (ADB)-аас олгосон 40 сая ам.долларын санхүүжилттэй хамтарсан төсөл нь тогтвортой санхүүжилтийн бодит үр нөлөөг харуулсан хэмээн үнэлэгдсэн юм. [APU Dairy's Role in Strengthening Mongolia's Dairy Sector: EBRD and ADB Support | SBFN](#)



2. ТоС холбооны “Тогтвортой байдлын удирдлага хариуцсан мэргэжлийн зөвлөл” болон шинээр байгуулагдсан “Бизнесийн мэргэжлийн зөвлөл”-д тус тус оролцон ажиллаж байна.

3. 2025 оны 4-р сард “Тогтвортой хөгжлийн” болон “Байгаль Орчин, Нийгэм, Засаглал (БОНЗ)”-ын тайлангаа 3 дахь жилдээ олон нийтэд хүргэлээ.

Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн 225 дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 4 дүгээр хавсралт

АПУ ХК-ийн 2025 оны эхний хагас жил

Хагас жилийн үйл ажиллагааны тайлан /маягт 2/			
Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.			
Тайлагнах хугацаа	2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2025 оны 06 дугаар сарын 30-ны өдөр		
Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар	Нэр: АПУ ХУВЬЦААТ КОМПАНИ УБГД: 000165753, РД: 2702673 ҮЦКод: АПУ Утас: 11-344336		
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр	Монголын хөрөнгийн бирж		
Бизнесийн үйл ажиллагааны салбар	Шингэн хүнсний үйлдвэрлэл		
Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тооширхэг	1,064,181,553		
Хагас жилийн тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр	Тайлагналын менежер Б.Буянхишиг, Комплайнсын мэргэжилтэн Б.Мягмар, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Сарантунгалаг		
1.	Хагас жилийн санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтүүдийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/		
Санхүүгийн байдлын үзүүлэлт	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
	Хөрөнгө		
	Эргэлтийн хөрөнгө	459,562,588,000	634,364,196,650
	Эргэлтийн бус хөрөнгө	618,993,441,000	608,477,730,956
	Нийт хөрөнгө	1,078,556,029,000	1,242,841,927,606
	Өр төлбөр ба эздийн өмч		
	Богино хугацаат өр төлбөр	149,687,247,504	140,372,624,557
	Урт хугацаат өр төлбөр	133,869,189,000	247,223,685,092
	Эздийн өмч	794,999,592,496	855,245,617,956
	Нийт өр төлбөр ба эздийн өмч	1,078,556,029,000	1,242,841,927,606
Орлогын тайлан	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
	Борлуулалтын орлого (цэвэр)	1,327,522,591,000	652,534,717,663
	Борлуулалтын өртөг	(680,502,489,000)	(330,236,177,878)
	Нийт ашиг (алдагдал)	647,020,102,000	322,298,539,785
	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	241,518,700,000	127,763,786,453
	Орлогын татварын зардал	(48,627,848,000)	(30,117,650,857)
	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	192,890,852,000	97,646,135,596
	Бусад дэлгэрэнгүй орлого	(574,399,000)	1,251,236,046
	Нийт орлогын дүн	192,316,453,000	98,897,371,642
	Толгой компанийн хувьцаа эзэмшигчдэд ноогдох	221,899,869,000	112,763,764,761
	Хяналтын эрхгүй хувь оролцоонд ноогдох	(29,583,416,000)	(13,866,393,119)

	<i>Өмчийн өөрчлөлтийн тайлан</i>	<table> <tr> <th>Үзүүлэлт</th><th>Эхний үлдэгдэл</th><th>Эцсийн үлдэгдэл</th></tr> <tr> <td>Өмч</td><td>106,418,200</td><td>106,418,200</td></tr> <tr> <td>Халаасны хувьцаа</td><td>-</td><td>-</td></tr> <tr> <td>Нэмж төлөгдсөн капитал</td><td>226,646,951,296</td><td>226,646,951,296</td></tr> <tr> <td>Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл</td><td>156,572,931,000</td><td>155,485,749,387</td></tr> <tr> <td>Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц</td><td>(457,461,000)</td><td>793,775,046</td></tr> <tr> <td>Хуримтлагдсан ашиг</td><td>392,482,641,000</td><td>435,910,550,383</td></tr> <tr> <td>Нийт эздийн өмчийн дүн</td><td>775,351,480,496</td><td>818,943,444,312</td></tr> <tr> <td>Хяналтын бус хувь оролцоо</td><td>19,648,112,000</td><td>36,302,173,645</td></tr> <tr> <td>Нийт дүн</td><td>794,999,592,496</td><td>855,245,617,956</td></tr> </table>	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өмч	106,418,200	106,418,200	Халаасны хувьцаа	-	-	Нэмж төлөгдсөн капитал	226,646,951,296	226,646,951,296	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	156,572,931,000	155,485,749,387	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	(457,461,000)	793,775,046	Хуримтлагдсан ашиг	392,482,641,000	435,910,550,383	Нийт эздийн өмчийн дүн	775,351,480,496	818,943,444,312	Хяналтын бус хувь оролцоо	19,648,112,000	36,302,173,645	Нийт дүн	794,999,592,496	855,245,617,956
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл																														
Өмч	106,418,200	106,418,200																														
Халаасны хувьцаа	-	-																														
Нэмж төлөгдсөн капитал	226,646,951,296	226,646,951,296																														
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	156,572,931,000	155,485,749,387																														
Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	(457,461,000)	793,775,046																														
Хуримтлагдсан ашиг	392,482,641,000	435,910,550,383																														
Нийт эздийн өмчийн дүн	775,351,480,496	818,943,444,312																														
Хяналтын бус хувь оролцоо	19,648,112,000	36,302,173,645																														
Нийт дүн	794,999,592,496	855,245,617,956																														
	<i>Мөнгөн гүйлгээний тайлан</i>	<table> <tr> <th>Үзүүлэлт</th><th>Эхний үлдэгдэл</th><th>Эцсийн үлдэгдэл</th></tr> <tr> <td>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</td><td>264,797,959,000</td><td>126,476,874,245</td></tr> <tr> <td>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</td><td>(124,392,028,000)</td><td>(71,823,081,857)</td></tr> <tr> <td>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</td><td>(168,266,198,000)</td><td>17,890,554,163</td></tr> <tr> <td>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</td><td>(27,860,267,000)</td><td>72,544,346,552</td></tr> <tr> <td>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</td><td>122,152,149,000</td><td>92,974,324,000</td></tr> <tr> <td>Мөнгөн хөрөнгийн үнэ цэнийн бууралт болон валютын ханшийн өөрчлөлт</td><td>(1,317,558,000)</td><td>1,465,790,206</td></tr> <tr> <td>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</td><td>92,974,324,000</td><td>166,984,460,758</td></tr> </table>	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	264,797,959,000	126,476,874,245	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(124,392,028,000)	(71,823,081,857)	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(168,266,198,000)	17,890,554,163	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(27,860,267,000)	72,544,346,552	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	122,152,149,000	92,974,324,000	Мөнгөн хөрөнгийн үнэ цэнийн бууралт болон валютын ханшийн өөрчлөлт	(1,317,558,000)	1,465,790,206	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	92,974,324,000	166,984,460,758						
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл																														
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	264,797,959,000	126,476,874,245																														
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(124,392,028,000)	(71,823,081,857)																														
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(168,266,198,000)	17,890,554,163																														
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(27,860,267,000)	72,544,346,552																														
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	122,152,149,000	92,974,324,000																														
Мөнгөн хөрөнгийн үнэ цэнийн бууралт болон валютын ханшийн өөрчлөлт	(1,317,558,000)	1,465,790,206																														
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	92,974,324,000	166,984,460,758																														
2.	<i>Хагас жилийн санхүүгийн тайланг хэлэлцэж, баталгаажуулсан төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хорооны дүгнэлт</i>																															
	АПУ ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 07 сарын 31-ний өдрийн ээлжит хурлаар АПУ Групп компанийн 2025 оны 1 дүгээр хагас жилийн тайланг хэлэлцэн батална.																															
3.	<i>Тайлант хугацаанд үнэт цаас гаргагчийн санхүүгийн үйл ажиллагаанд нөлөөлсөн гадаад дотоод хүчин зүйлс, санхүүгийн тайлангийн шинжилгээ, орлого, зарлага, ашигийн үзүүлэлтүүдийг тооцож дүгнэсэн удирдлагын тайлан, дүгнэлт</i>																															
3.1.	<i>Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/</i>	<table> <tr> <th>Харьцаанууд</th><th>2024</th><th>2025Q2</th></tr> <tr> <td>Нийт ашгийн хувь</td><td>49%</td><td>49%</td></tr> <tr> <td>Үйл ажиллагааны ашгийн хувь</td><td>18%</td><td>20%</td></tr> <tr> <td>Цэвэр ашгийн хувь</td><td>15%</td><td>15%</td></tr> <tr> <td>Өөрийн хөрөнгийн өгөөж</td><td>25%</td><td>12%</td></tr> <tr> <td>Нэгж хувьцаанд ногдох ашиг</td><td>209,056.60</td><td>104,787.08</td></tr> </table>	Харьцаанууд	2024	2025Q2	Нийт ашгийн хувь	49%	49%	Үйл ажиллагааны ашгийн хувь	18%	20%	Цэвэр ашгийн хувь	15%	15%	Өөрийн хөрөнгийн өгөөж	25%	12%	Нэгж хувьцаанд ногдох ашиг	209,056.60	104,787.08												
Харьцаанууд	2024	2025Q2																														
Нийт ашгийн хувь	49%	49%																														
Үйл ажиллагааны ашгийн хувь	18%	20%																														
Цэвэр ашгийн хувь	15%	15%																														
Өөрийн хөрөнгийн өгөөж	25%	12%																														
Нэгж хувьцаанд ногдох ашиг	209,056.60	104,787.08																														
3.2.	<i>Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт</i>	<table> <tr> <th>Харьцаанууд</th><th>2024</th><th>2025Q2</th></tr> <tr> <td>Эргэлтийн харьцаа</td><td>3.07</td><td>4.52</td></tr> <tr> <td>Түргэн хөрвөх чадварын харьцаа</td><td>1.43</td><td>2.54</td></tr> <tr> <td>Өр болон өөрийн хөрөнгийн харьцаа</td><td>0.36</td><td>0.45</td></tr> </table>	Харьцаанууд	2024	2025Q2	Эргэлтийн харьцаа	3.07	4.52	Түргэн хөрвөх чадварын харьцаа	1.43	2.54	Өр болон өөрийн хөрөнгийн харьцаа	0.36	0.45																		
Харьцаанууд	2024	2025Q2																														
Эргэлтийн харьцаа	3.07	4.52																														
Түргэн хөрвөх чадварын харьцаа	1.43	2.54																														
Өр болон өөрийн хөрөнгийн харьцаа	0.36	0.45																														
3.3.	<i>Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчны нөлөөлөл, бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөл хэлбэрт гарч буй өөрчлөлт, дээрх өөрчлөлтөд компанийн зүгээс авч хэрэгжүүлж буй арга хэмжээний мэдээлэл</i>	Инфляц болон гадаад валютын ханшийн өсөлтөөс хамаарч иргэдийн худалдан авах чадвар муудаж байгаа нь бизнесийн өсөлтөд сөрөг нөлөө үзүүлж байна. Үүний эсрэг ажлын капиталын удирдлага болон санхүүгийн хэрэгслүүдийг ашиглах, техник технологийн дэвшил ашиглан бүтээмжээ сайжруулах, тогтвортой хөгжилд чиглэсэн хөрөнгө оруулалт хийх гэх мэт замаар хариу арга хэмжээ авч ажиллаж байна.																														
3.4.	<i>Санхүүгийн байдлын тайлангийн гадуурбүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлого</i>	Байхгүй																														
4.	<i>Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй хэлцэл болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийгдэх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/</i>																															

	- Тайлант хугацаанд их хэмжээний хэлцэл хийгдээгүй - Сонирхлын зөрчилтэй этгээдтэй хийсэн ажил гүйлгээг жилийн эцсийн тайлангаар толилуулна.
5.	<i>Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор олон нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойших төслийн хэрэгжилтийн явц, татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан, мэдээлэл</i>
	Тайлант хугацаанд олон нийтэд санал болгон хувьцаа гаргаагүй.
6.	<i>Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл</i>
	Хувьцаа эзэмшигчдийн хурал АПУ ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал цахим хэлбэрээр 2025 оны 04 сарын 24-ний өдрийн 14:00-15:17 цагийн хооронд 87.91%-ийн ирцтэй хуралдаж дараах шийдвэрийг гаргав: 1. АПУ ХК-ийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан “АПУ групп компани 2024 онд тавьсан зорилтуудаа биелүүлж, амжилттай ажилласан” гэсэн дүгнэлтийг батлав. 2. АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшууллыг ТУЗ-ийн дарга 10 сая, ТУЗ-ийн гишүүд 6.5 сая байхаар батлав. Төлөөлөн удирдах зөвлөл ТУЗ-ийн бүрэлдэхүүн өөрчлөгдөөгүй. ТУЗ-ийн бүрэлдэхүүн: ТУЗ-ийн ердийн гишүүн бөгөөд ТУЗ-ийн дарга ПҮРЭВИЙН БАТСАЙХАН (Инженер мэргэжилтэй) Шунхлай холдинг ХХК-ийн Ерөнхийлөгч 2002 оноос хойш АПУ ХК-ийн ТУЗ-ийн дарга Хувьцаа эзэмшил: Хувь хүн: 91,647 ширхэг (0.01%) Шунхлай холдинг ХХК: 602,651,260 ширхэг (56.63%)  ТУЗ-ийн ердийн гишүүн БҮРЭНТОГТОХЫН БАТБАЯР (Эдийн засагч мэргэжилтэй) Шунхлай холдинг ХХК-ийн Гүйцэтгэх дэд ерөнхийлөгч 2013 оноос хойш АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүн Хувьцаа эзэмшил: Хувь хүн: 82,267 ширхэг (0.01%) Шунхлай холдинг ХХК: 602,651,260 ширхэг (56.63%)  ТУЗ-ийн ердийн гишүүн КЕННЕТ ЧУ (Нягтлан бодогч, менежмент мэргэжилтэй) Хайнекен Азия Пасифик компанийн Ази-Номхон далайн бүс хариуцсан Гүйцэтгэх захирал 2018 оноос хойш АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүн Хувьцаа эзэмшил: Хувь хүн: 0 ширхэг (0.00%) Хайнекен Азия Пасифик Пте Лтд: 266,091,981 ширхэг (25.00%)  ТУЗ-ийн ердийн гишүүн СЭН И-ИН (Хуульч мэргэжилтэй) Хайнекен Азия Пасифик компанийн Ази-Номхон далайн бүсийн Хууль эрхзүй хариуцсан захирал 2020 оноос хойш АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүн Хувьцаа эзэмшил: Хувь хүн: 82,267 ширхэг (0.01%) Хайнекен Азия Пасифик Пте Лтд: 266,091,981 ширхэг (25.00%)  ТУЗ-ийн ердийн гишүүн БАТСАЙХАНЫ ГАНТИГ (Бизнесийн удирдлага, менежмент мэргэжилтэй) Шунхлай холдинг ХХК-ийн Стратеги хариуцсан захирал Дижитал концепт ХХК-ийн Гүйцэтгэх захирал 2024 оноос хойш АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүн Хувьцаа эзэмшил: Хувь хүн: 1,000 ширхэг (0.00%) Шунхлай холдинг ХХК: 602,651,260 ширхэг (56.63%) 

ТУЗ-ийн ердийн гишүүн БАЯРЦОГТЫН ГОМБО-ЭРДЭНЭ (Хэрэглээний математикч, эдийн засагч, санхүүч мэргэжилтэй) Шунхлай холдинг ХХК-ийн Бизнес хөгжил хариуцсан захирал 2024 оноос хойш АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүн Хувьцаа эзэмшил: Хувь хүн: 100 ширхэг (0.00%) Шунхлай холдинг ХХК: 602,651,260 ширхэг (56.63%)	
ТУЗ-ийн хараат бус гишүүн ЁНДОН-ОЙДОВЫН ГЭРЭЛЧУЛУУН (Эдийн засагч мэргэжилтэй) Нээлттэй хот ТББ-ын үүсгэн байгуулагч 2017 оноос хойш АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүн Хувьцаа эзэмшил: 0 ширхэг (0.00%)	
ТУЗ-ийн хараат бус гишүүн ОДОНЧИМЭДИЙН ОДБАЯР (Багш, эрх зүйч мэргэжилтэй) Ард даатгал ХК, Ард холдинг ХХК, Монгол шуудан ХК-уудын ТУЗ-ийн гишүүн 2021 оноос хойш АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүн Хувьцаа эзэмшил: 0 ширхэг (0.00%)	
ТУЗ-ийн хараат бус гишүүн ЖИГЖИДИЙН ҮНЭНБАТ (Эдийн засагч мэргэжилтэй) 2013 оноос хойш АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүн Хувьцаа эзэмшил: 0 ширхэг (0.00%)	
Гүйцэтгэх удирдлагын баг Компанийн гүйцэтгэх удирдлагыг Гүйцэтгэх захирал хэрэгжүүлж, гүйцэтгэх удирдлагын багийг удирдан ажилладаг. Гүйцэтгэх удирдлагын багийн бүрэлдэхүүнд гарсан өөрчлөлт: - Үйлдвэрлэл, үйл ажиллагаа эрхэлсэн захирал Алеш Заховал 2025 оны 02 дугаар сард зуурдаар нас барсан тул хагас жилийн эцэс хүртэл гүйцэтгэх захирал Ц.Эрдэнэбилэг орлон ажиллав. - Дижитал шилжилт, өөрчлөлт эрхэлсэн захирлын албан тушаал 2025 оны 03 дугаар сард нэмэгдэж, Сингапур улсын иргэн Онг Киен Лам (Аллан Онг) шинээр томилогдсон.	
Гүйцэтгэх удирдлагын багийн бүрэлдэхүүн:	
Гүйцэтгэх захирал ЦЭВЭЭНЖАВЫН ЭРДЭНЭБИЛЭГ	
Санхүү эрхэлсэн захирал ГОНЧИГИЙН ЭНХБИЛЭГ	
Үйлдвэрлэл, үйл ажиллагаа эрхэлсэн захирал АЛЕШ ЗАХОВАЛ (2025 оны 2-р сар хүртэл)	
Борлуулалт, маркетинг эрхэлсэн захирал БАТСАЙХАНЫ ЦАЦРАЛ	
Захиргаа, хүний нөөц эрхэлсэн захирал ЖАРГАЛСАЙХАНЫ ИЧИНХОРЛОО	
Дижитал шилжилт, өөрчлөлт эрхэлсэн захирал АЛЛАН ОНГ (2025 оны 3-р сараас хойш)	
АПУ Дэйри ХХК-ийн Гүйцэтгэх захирал ГАЛСУМЪЯАГИЙН БАЯРМАГНАЙ	
Бусад эрх бүхий албан тушаалтан Компанийн дүрэмд заасны дагуу ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх захирал, Гүйцэтгэх удирдлагын багийн гишүүдээс гадна ТУЗ-ийн нарийн бичгийн дарга, Ерөнхий нягтлан бодогч нь компанийн эрх бүхий албан тушаалтанд тооцогдоно. Тайлант хугацаанд ТУЗ-ийн нарийн бичгийн даргаар Базаррагчаагийн Сарантунгалаг, Ерөнхий нягтлан бодогчоор Батсуурийн Даваадорж ажиллав.	

7.

Үнэт цаас гаргагчийн засаглалтай холбоотой тайлан, мэдээлэл

АПУ Групп компанийн бүтэц

Тайлант хугацаанд АПУ Групп компанийн бүтцэд өөрчлөлт гараагүй.

Хувьцаа эзэмшигчдийн бүтэц

АПУ ХК-ийн хувьцаа эзэмшигчид (2025 оны 04 сарын 04-ний өдрийн байдлаар)

Д/д	Хувьцаа эзэмшигч	Хувьцааны тоо ширхэг	Эзэмшлийн хувь
1	ШУНХЛАЙ ХОЛДИНГ ХХК	602,651,260	56.63
2	HEINEKEN ASIA PACIFIC PTE LTD	266,091,981	25.00
3	STEPPE BEVERAGE KFT	58,829,058	5.53
4	Бусад	136,609,254	12.84

Өнгөрөгч оны мөн үетэй харьцуулбал нөлөө бүхий хувьцаа эзэмшигч Шунхлай холдинг ХХК-ийн эзэмшлийн хувь 0.6%-аар нэмэгдэж, Steppe Beverage KFT-ийн эзэмшлийн хувь 0.11%-аар буурсан байна.

Ногдол ашгийн мэдээлэл

ТУЗ-ийн 2025 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 25/02 тоот тогтоолоор 2024 оны хоёрдугаар хагас жилийн санхүүгийн үр дүнг харгалзан нэгж хувьцаанд ₮65 (жаран таван төгрөг)-ийн ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэв.

Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалт гарах бүртгэлийн өдрийг 2025 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдөр (2025 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр)-өөр тогтоож, ногдол ашгийг 2025 оны 08 дугаар сарын 19-ний өдрийн дотор төлөхөөр тогтлоо.

Тус ногдол ашгийн төлбөрийг нийт хувьцааны таваас доош хувийг эзэмшигчдэд “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-аар зуучлуулан 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр хувьцаа эзэмшигчдийн төвлөрсөн хадгаламжийн дансанд байршуулсан ба таваас дээш хувийг эзэмшигчдэд компаниас шууд төлөх замаар мөнгөн хэлбэрээр олгов.

Компанийн засаглалын кодексийн хэрэгжилт

АПУ ХК-ийн 2024 оны нэгдүгээр хагас жилийн компанийн засаглалын өөрийн үнэлгээний тайлангаар нийт 72 онооноос 71 оноо буюу 98.6%-аар үнэлснээр “засаглал хэвийн буюу эрсдэлгүй” түвшинд үнэлэгдлээ.

№	Гарчиг	Авбал зохих нийт оноо	Үнэлсэн оноо	Үнэлгээний хувь
1	ТУЗ-ийн бүтэц, зохион байгуулалт	12	12	100%
2	ТУЗ-ийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэг	10	10	100%
3	Тайлагнал, мэдээллийн ил тод, байдал	6	6	100%
4	Аудит, хяналтын тогтолцоо	6	6	100%
5	Эрсдэлийн удирдлага	8	8	100%
6	Эрх бүхий албан тушаалтны цалин урамшуулал	6	6	100%
7	Оролцогч талуудын эрх ашиг	8	8	100%
8	Компанийн соёл	6	6	100%
9	Хувьцаа эзэмшигчдийн эрх	10	9	90%
	Нэгдсэн дүн	72	71	98.6%

Хувьцааны мэдээлэл

АПУ ХК-ийн хувьцааны хаалтын ханш оны эхэнд ₮999.51 байсан бол хагас жилийн эцэст ₮968.18 болж буурсан байна. Зах зээлийн үнэлгээ хагас жилийн эцэст 1.03 их наяд төгрөг байснаар Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй хувьцаат компаниудаас дөрөвдүгээр байранд жагсав.

Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: Ц.Эрдэнэбилэг

Албан тушаал: "АПУ" ХК-ийн гүйцэтгэх захирал

Гарын үсэг:



(Тамга/тэмдэг)

Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: Б.Сарантунгалаг ~Г

Албан тушаал: ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

Гарын үсэг:

Б. Салан